



МУИС-ийн Байгаль-Эх ахлах сургууль,
Экологийн боловсролын төвийн хамт
олны 2015 оны 04 дүгээр сарын 17-ны
өдрийн хурлаар хэлэлцэж батлав

УХА0559 5919711

БЭЛАС-ИЙН СУРАГЧИЙН ШИЛЖИЛТ ХӨДӨЛГӨӨНИЙ ЖУРАМ

НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

1.1. Байгаль-Эх лицей ахлах сургууль /цаашид БЭЛАС гэх/-ийн сурагчдад чөлөө олгох, БЭЛАС-д шилжин суралцах, тус сургуулиас шилжих хөдөлгөөн хийх үйл ажиллагааг энэхүү журмаар зохицуулна.

ХОЁР. ЧӨЛӨӨ ОЛГОХ

2.1. Хүндэтгэн үзэх шалтгааны (өвчний учир, гадаад явах, ар гэрийн гачигдал) учир нэг сараас дээш хугацаагаар суралцах боломжгүй болсон суралцагчдад, эцэг эхийн хүсэлтийг харгалзан урт хугацаатай чөлөөг олгоно.

2.2. Чөлөө авах хүсэлтэй сурагчийн эцэг эх сургуулийн захиргаанд өргөдөл гаргана.

2.3. Анги удирдсан багш болон номын санчийн тооцоогүй болохыг нотолсон гарын үсгийг өөрийн биеэр болон эцэг эх нь зуруулна.

2.4. Дээрхи хуудсыг үндэслэн захирал чөлөө олгож тушаалаар баталгаажуулна. Тушаалд чөлөөний хугацааг тодорхой заана.

ГУРАВ. СУРАГЧИЙН ШИЛЖИЛТ ХӨДӨЛГӨӨН

3.1. БЭЛАС-д шилжин суралцах

3.1.1. БЭЛАС-д сурагч шилжин суралцах хүсэлтийг хичээлийн жил, улирлын хичээл эхлэхээс 3 хоногт дуусгавар болгоно.

3.1.2. 10,11,12 дугаар ангийн хүүхдийн тоо цөөрснөөс нэмэлт элсэлт авах шаардлагатай бол математик, англи хэл хичээлийн агуулгаар шалгалт ёгч, тэнцсэн тохиолдолд элсүүлнэ.

3.1.3. Шилжин суралцах болзол хангасан суралцагчийн эрх БЭЛАС-ийн захирлын тушаалаар баталгаажна.

3.1.4. БЭЛАС-т шилжин суралцах сурагч нь дараах баримт бичгийг бүрдүүлэн сургалтын менежерт хандана:

- Сурагчийн хувийн хэрэг
- Суралцах эрхийн бичиг
- Суралцаж байсан сургуулийн дүнгийн баталгаажуулсан тодорхойлолт.
- Сургалтын төлбөрийн баримт

3.2. БЭЛАС-аас шилжих суралцагч

3.2.1. БЭЛАС-аас суралцагч өөр сургуульд шилжих хүсэлт гаргасан тохиолдолд тодорхой тэмдэглэлийг хувийн хэргийн зохих хүснэгтэнд сургалтын менежер бичиж, захирал баталгаажуулна.

3.2.2. Шилжин явж байгаа суралцагчаас гуравласан гэрээний 7.4-т заасны дагуу тооцооны хуудсыг анги удирдсан багш, номын санчаар тооцоогүй болохыг нотолсон гарын үсгийг зуруулна.